

ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ТАЙЛАН 2024

Үндэсний давхар даатгал ХК



АГУУЛГА

УДИРТГАЛ	Удирдлагын амлалт	02
	Компанийн танилцуулга	03
	Онцлох үзүүлэлтүүд	04
	Тайлангийн хамрах хүрээ	05
ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН СТРАТЕГИ	Тогтвортой хөгжлийн стратеги	07
	Материаллаг байдал ба оролцогч талууд	08
	БОНЗ-ын тогтолцоо	09
БАЙГАЛЬ ОРЧИН	Тогтвортой хэрэглээ	11
	Тогтвортой хөрөнгө оруулалт	13
	Байгаль орчны эрсдэл	14
	Байгалийн гамшгийн хамгаалалт	15
НИЙГЭМ	Тогтвортой ажлын байр	18
	Тогтвортой хамтын ажиллагаа	20
	Тогтвортой ханган нийлүүлэлтийн сүлжээ	21
	Нийгэмд чиглэсэн үйл ажиллагаа	22
ЗАСАГЛАЛ	Компанийн засаглал	24
	Ёс зүй ба комплаенс	25
	Эрсдэлийн удирдлага	27
	Мэдээллийн аюулгүй байдал	28
ХАВСРАЛТ	GRI стандарт	30
	SASB удирдамж	32
	Тогтвортой хөгжлийн зорилгууд	35
	БОНЗ, Тогтвортой байдлын тайлагналын удирдамж	36

Удирдлагын амлалт

Сайн байцгаана уу?

Эрхэм хүндэт харилцагчид, даатгуулагчид, хөрөнгө оруулагчид, хамтран ажиллагч түншүүд ээ,

“Үндэсний Давхар Даатгал” ХК нь Монгол Улсын цорын ганц үндэсний давхар даатгагчийн хувьд нийгэм, эдийн засаг, хүрээлэн буй орчинд үзүүлж буй нөлөөгөө ухамсарлан, тогтвортой хөгжилд хувь нэмрээ оруулах үүрэг хариуцлагыг хүлээн ажиллаж байна. Бид анхны Байгаль орчин, нийгэм, засаглалын (БОНЗ/ESG) тайлангаа олон улсын стандартуудын дагуу боловсруулж, нээлттэй мэдээлэл болгон нийтэлж байгаадаа баяртай байна.

Энэ тайлангаар бид GRI (2021), SASB, НҮБ-ын Тогтвортой хөгжлийн зорилгууд (SDGs)-тай уялдуулсан бодлого, үйл ажиллагаагаа ил тод танилцуулж байгаа бөгөөд манай компанийн урт хугацааны үнэ цэнийг нэмэгдүүлэх, эрсдэлд тэсвэртэй бизнесийн тогтолцоог бүрдүүлэх чиглэлээр хийж буй хүчин чармайлтуудыг харуулж байна.

Сүүлийн жилүүдэд уур амьсгалын өөрчлөлт, байгалийн гамшиг, нийгмийн тэгш бус байдал зэрэг глобал сорилтууд гүнзгийрч, давхар даатгалын оролцоо урьд өмнөхөөс илүү чухал ач холбогдолтой болж байна. Ийм нөхцөлд бид санхүүгийн тогтвортой байдлаа хадгалах, хүний нөөцийн чадавх, технологийн шинэчлэл, засаглалын ил тод байдлыг нэмэгдүүлэхэд онцгойлон анхаарч ажиллаж байна.

Манай хамт олон ESG зарчмыг зөвхөн гадаад бодлогын хүрээнд бус, компанийн дотоод соёл, удирдлагын тогтолцоонд шингээн хэрэгжүүлж байна. Тухайлбал, эрчим хүч, цаасны хэрэглээг бууруулах, ногоон оффисын жишиг тогтоох, хүний эрх, жендерийн тэгш байдлыг хангах, засаглалын хяналт-шинжилгээ, ёс зүйн дүрмийг тасралтгүй сайжруулах зэрэг олон санаачилгыг хэрэгжүүллээ.

Энэхүү тайланг гаргах нь бидний хувьд зүгээр нэг үүрэг биш, харин ч урагшлах, хариуцлагаа нэмэгдүүлэх чухал алхам юм. Цаашид жил бүр тайлангаа шинэчлэн олон нийтэд мэдээлэхийн зэрэгцээ, олон улсын түншүүд, оролцогч талуудтай ил тод, харилцан үр дүнтэй хамтын ажиллагааг хөгжүүлж, Төв Азийн бүс нутагт тогтвортой давхар даатгалын тэргүүлэх жишиг тогтоохыг зорьж байна.

Хамтран ажиллагч бүх байгууллага, харилцагчдадаа гүн талархал илэрхийлж, ногоон, тогтвортой ирээдүйн төлөө бидэнтэй хамт алхахыг уриалж байна.



ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
БАТМӨНХИЙН ЖАВХЛАНТ

Компанийн танилцуулга

“Үндэсний давхар даатгал” ХК нь Монгол Улсын эдийн засгийн тогтвортой хөгжлийг хангах, валютын гадагшлах урсгалыг бууруулах, давхар даатгалын тогтолцоог хөгжүүлэх зорилгоор 2014 онд байгуулагдсан төрийн өмчит хувьцаат компани юм. Бид олон улсын зээлжих зэрэглэл тогтоогч AM Best агентлагаас хоёр дахь жилдээ ерөнхий санхүүгийн чадавхын хувьд В, урт хугацааны зээлжих зэрэглэлийн хувьд ВВ+, цаашдын төлөвөө “Тогтвортой” гэсэн үнэлгээ авч, компанийн хөрөнгө, үйл ажиллагааны үнэ цэнийг нэмэгдүүлэх, гүйцэтгэлийн болон чанарын бодлогыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд үйл ажиллагаандаа ISO 9001:2015 стандартыг нэвтрүүлэн ажиллаж байна.




Алсын хараа

Бид Хувьцаа эзэмшигчдийн хөрөнгийн өгөөжийг нэмэгдүүлэн, ашигт ажиллагааг дээдлэгч, Төв Азийн тэргүүлэх давхар даатгагчдын нэг, Мэргэшлийн дээд түвшний стандартыг тогтоогч, Монгол Улсын давхар даатгалын жишиг компани, Мэргэжлийн хөрөнгө оруулагч болно.



Эрхэм зорилго

Бид үйлчлүүлэгчдийнхээ хөрөнгө, санхүүгийн эрсдэлгүй найдвартай байдлыг ханган давхар даатгалын үйлчилгээ үзүүлж, үндэсний давхар даатгалын тогтолцоог хөгжүүлнэ.



Үнэт зүйл

МЭРГЭШСЭН ӨНДӨР ЧАДАВХ: Даатгалын мэргэжлийн өндөр ур чадвартай боловсон хүчин

МАНЛАЙЛАЛ: Цаашдын зорилго, зорилтыг тодорхойлон бусдад үлгэрлэх, чиглүүлэн нэгтгэх, хамтдаа бодит үйл хэрэг болгоно.

ХАМТЫН ЗҮТГЭЛ: Бусадтай хүндлэлтэй хандаж, итгэлцэл бий болгон хамт олонтойгоо үр дүнтэй хамтран ажиллаж бүтээмжийг нэмэгдүүлнэ.

ҮНЭНЧ ШУДАРГА ЗАРЧИМ: Монгол Улсын хууль тогтоомжийг чандлан мөрдөж, “Үндэсний давхар даатгал” ХК-ийн ёс зүйн дүрмийг өдөр тутамд мөрдлөг болгон ажиллана.

ИЛ ТОД ХАРИЛЦАА ХОЛБОО: Мэдээллийн ил тод байдлыг хангах үүргээ биелүүлж, шударга, нээлттэй харилцаа холбоо тогтооно.

Онцлох үзүүлэлтүүд

Олон улсын зэрэглэл

AM Best 2024




B тогтвортой

Санхүүгийн
чадавхи

BB+

Зээлжих
зэрэглэл

Даатгалын нийт хураамжийн орлого



Нийт хураамжийн орлого өмнөх оны мөн үеэс 12.7%-иар өссөн.

Нийт хөрөнгө



62.34
тэрбум төгрөг

Нийт орлого




24.97
тэрбум төгрөг

Ашигт ажиллагаа



1.13
тэрбум төгрөг

Нийт нөхөн төлбөр



Төлбөрийн чадвар



133.8%
Шалгуур >100%

Тайлангийн хамрах хүрээ

Энэхүү тайлангаар дамжуулан бид Үндэсний Давхар Даатгал ХК-ийн Байгаль орчин, Нийгэм, Засаглал (ESG)-ын хүрээн дэх үйл ажиллагаа болон НҮБ-ын Тогтвортой хөгжлийн зорилгуудтай (SDGs) уялдуулсан бодлого, арга хэмжээг ил тод танилцуулж байна.


Манай байгууллага тогтвортой хөгжлийн тайланг анх удаа боловсруулж, нийтэд мэдээлж буй нь урт хугацааны өсөлт, үнэ цэнийг бий болгох стратегийн нэг хэсэг юм. Цаашид энэхүү тайланг тогтмол, тасралтгүй шинэчлэн гаргаж, оролцогч талуудтай ил тод, үр дүнтэй харилцааг хөгжүүлэхийг зорьж байна.

Тайланд дурдсан үйл ажиллагаа болон санхүүгийн тоон үзүүлэлтүүд, мэдээллийг 2024 оны жилийн тайлан болон аудитлагдсан тайлангаас харах боломжтой. Тайлантай холбоотой асуулт, санал хүсэлт, сэтгэгдлийг info@mongolian.re.com хаягаар илгээнэ үү.

Тайлангийн хамрах хүрээ

Тайланд тусгасан үйл ажиллагаа, мэдээлэл нь 2024 оны санхүүгийн жилийн хугацаанд хийгдсэн ажил, хүрсэн үр дүн, мөн баталгаажсан аудитын тайлан дээр үндэслэсэн болно.

Энэхүү тайланг GRI стандарт (2021 он) – Тогтвортой байдлын тайлагналын дэлхий дахины жишиг, SASB – Даатгалын салбарын тайлагналын стандарт, НҮБ-ын Тогтвортой хөгжлийн зорилгууд (SDGs) зэрэг стандартууд болон удирдамжийн дагуу боловсруулсан. Тайланд SDG зорилтуудтай уялдсан үйл ажиллагааг танихад хялбар байлгах үүднээс тухайн зорилгын таних дүрс, тэмдгүүдийг ашигласан. Мөн дэлгэрэнгүй мэдээлэл, холбогдох тайлбар, тодруулгуудыг хавсралтаас үзэх боломжтой.



01 Тогтвортой хөгжил

Тогтвортой хөгжлийн стратеги

Материаллаг байдал ба оролцогч талууд

БОНЗ-ын тогтолцоо

Тогтвортой хөгжлийн стратеги

Бидний үйл ажиллагаа болон стратеги зорилтууд нь НҮБ-ын Тогтвортой хөгжлийн зорилтуудтай уялдаж байгааг үнэлж, дараах **нэн тэргүүний зорилтуудыг** тодорхойлон ажиллаж байна. Эдгээр зорилтууд нь бидний салбарын онцлог, оролцогч талуудын хүлээлт, нийгэм, байгаль орчинд үзүүлэх нөлөөлөлд үндэслэн тодорхойлогдсон болно.

Тогтвортой хөгжлийн зорилт		Тайлбар	Үйл ажиллагааны чиглэл	Хэмжих үзүүлэлт	2024 оны үзүүлэлт
	8. Зохистой хөдөлмөр ба эдийн засгийн өсөлт	Даатгалын хүртээмжийг нэмэгдүүлж, эдийн засгийн тогтвортой байдлыг дэмжих	- Давхар даатгалын үйлчилгээний цар хүрээ	- Даатгуулагчдын тоо - Давхар даатгасан хөрөнгийн хэмжээ	- Давхардсан тоогоор 237 аж ахуйн нэгжийн 3.0 их наяд төгрөгийн үнэлгээ бүхий эд хөрөнгө болон эдийн бус ашиг сонирхлыг давхар даатгалаа.
	13. Уур амьсгалын өөрчлөлттэй тэмцэх	Уур амьсгалтай холбоотой эрсдэлд даатгалын хариу арга хэмжээ үзүүлэх	- Гамшгийн даатгалууд - Уур амьсгалын эрсдэлийн үнэлгээ	- Гамшгийн нөхөн төлбөр	- Нөхөн төлбөрт 16.8 тэрбум төгрөг олгосон.
	17. Хамтын ажиллагаа ба түншлэл	Олон улсын байгууллага, давхар даатгагчидтай түншлэх	- Олон улсын давхар даатгалын гэрээ - Сургалт, хамтарсан төсөл	- Гадаад түншлэлийн тоо - Хамтын төсөл хэрэгжилт	- Олон улсын хамтран ажиллагч байгууллага 16 - Хамтран хэрэгжүүлж буй төсөл, сургалт 3

Материаллаг байдал ба оролцогч талууд

Оролцогч талууд

- Хувьцаа эзэмшигчид
- Хөрөнгө оруулагчид
- Ажилтнууд
- ОУ-ын давхар даатгагчид
- Даатгагчид
- Мэргэжлийн оролцогч талууд
- Даатгуулагчид
- Төрийн ба төрийн бус байгууллагууд
- Олон нийт

БОНЗ-ын асуудлууд

БОНЗ-ын стратеги

БАЙГАЛЬ ОРЧИН

- Эрсдэлийн удирдлага ба давхар даатгалын тогтвортой байдал
- Байгалийн гамшиг ба уур амьсгалын өөрчлөлтөд хариу арга хэмжээ
- Байгальд ээлтэй дотоод үйл ажиллагаа (цаасгүй, ногоон оффис)

Байгалийн гамшгийн хамгаалалт, эрсдэлийн үнэлгээний тогтолцоог бэхжүүлэх, дотоод үйл ажиллагааг байгальд ээлтэй болгох

НИЙГЭМ

- Хүний нөөц ба ажилтны хөгжил
- Олон нийтийн оролцоо ба нийгмийн хариуцлага

Санхүүгийн боловсрол, нийгмийн тэгш байдлыг дэмжих, хүний нөөцийн чадавхыг хөгжүүлэх

ЗАСАГЛАЛ

- Ил тод байдал
- Мэдээллийн аюулгүй байдал ба нууцлал

Бизнесийн ёс зүйтэй, ил тод, нээлттэй, хариуцлагатай засаглалыг төлөвшүүлэх

Байгаль орчин, нийгэм, засаглалын тогтолцоо

БАЙГАЛЬ ОРЧИН

- Давхар даатгалын үйлчилгээгээр дамжуулан уур амьсгалын өөрчлөлтийг бууруулахад хувь нэмрээ оруулах
- Ногоон санхүүжилт, тогтвортой санхүүжилтийн хүрээнд давхар даатгалын хамгаалалтыг нэвтрүүлэх, ногоон шилжилтийг дэмжих

НИЙГЭМ

- Даатгалын тогтолцоогоор гамшгийн улмаас нийгэмд учрах хор хохирлыг бууруулах
- Ажлын байрны тогтвортой байдлыг бий болгон ажилтнуудынхаа эрүүл мэнд, сургалт хөгжилд анхаарах
- Санхүүгийн боловсрол, олон нийтийн оролцоог дэмжих

ЗАСАГЛАЛ

- Ил тод, нээлттэй, тогтвортой засаглалтай байх
- Ашиг сонирхлоос ангид байж, ёс зүйтэй бизнесийг хэрэгжүүлэх
- Хууль, дүрэм журмын нийцлийг ханган ажиллах

Тогтвортой хэрэглээ

Бид байгууллагын байгаль орчинд үзүүлэх нөлөөг бууруулах, хариуцлагатай хэрэглээний соёлыг төлөвшүүлэх, тогтвортой хөгжлийн зорилгод хувь нэмэр оруулахад чиглэж байна.

Байгаль орчны хариуцлага

Манай компани нь 2018 оноос хойш жил бүр тасралтгүй мод тарих үйл ажиллагаанд оролцож байгаа бөгөөд 2024 онд хамт олноороо “Шинэ Налайх” цэцэрлэгт хүрээлэнд 50 бут буйлс мод тарив.



Нийт 200

бут мод тарьж “Тэрбум
мод - Үндэсний
хөтөлбөр”-т хувь
нэмрээ оруулсан.



Эрчим хүчний хэмнэлт:

Ажлын байранд эрчим хүчний үр ашигтай хэрэглээг уриалж, ажилтнуудад эрчим хүчний хэмнэлтийн талаарх сургалт, зөвлөмжийг тогтмол хүргэн ажиллаж байна.



Найдвартай, урт хугацаанд ашиглагдах бараа, тоног төхөөрөмж сонгох:

Богино настай, хурдан элэгдэх хэрэглээг багасгах, засварлах боломжтой бараа бүтээгдэхүүн худалдан авдаг.



Цаас хэмнэлт:

Цаасгүй ажлын орчныг дэмжин, цахим шийдлийг түлхүү ашиглахыг зорьдог бөгөөд хэрэглэсэн цаасны дахин ашиглалтыг дэмждэг.

Тогтвортой хэрэглээ

Цаасны хэмнэлт

2024 онд Малын индексжүүлсэн даатгалын танилцуулга брошуруудыг цаасан хэлбэртэй байсныг цахим болгон Midcalculator аппликэйшнд оруулснаар цаасны хэрэглээг 78%-р бууруулсан.

Хүлэмжийн хийн ялгарал

Манай компани 2024 оны үйл ажиллагааны хүрээнд нийт 169.0 тонн CO₂e хүлэмжийн хий ялгаруулсан бөгөөд дараах байдлаар ангилсан байна:

Score 1 (шууд ялгаруулалт): байгууллагын автомашины шатахуун хэрэглээнээс шалтгаалж 5.59 тн CO₂e.

Score 2 (шууд бус): цахилгаан болон дулаан хэрэглээнээс үүсэх 159.68 тн CO₂e.

Score 3 (бусад шууд бус): албан томилолт, ажилчдын зорчих хөдөлгөөн, хог хаягдлаас үүсэх 3.78 тн CO₂e.

Ялгарлын тооцооллыг GHG Protocol Corporate Standard болон GRI 305:2016 стандартад нийцүүлэн гүйцэтгэж, Монгол Улсад хэрэглэгдэх CO₂e коэффициентуудыг ашигласан болно.

5.59

(тонн CO₂e)

Хүрээ 1:

159.68

(тонн CO₂e)

Хүрээ 2:

3.78

(тонн CO₂e)

Хүрээ 3:


169.05

(тонн CO₂e)

Нийт

Тогтвортой хөрөнгө оруулалт

Хөрөнгө оруулалтын хэмжээ, тэрбум төгрөг



2024 оны байдлаар хөрөнгө оруулалтын багцын ихэнх хувийг банк санхүүгийн байгууллагад оруулсан хөрөнгө оруулалт эзэлж байгаа бөгөөд бид цаашид хөрөнгө оруулалтын багцдаа дараах хөрөнгүүдийг нэмэх бодлого баримтлан ажиллана. Үүнд:

- Ногоон бонд, тогтвортой хөгжлийн зорилтот бонд
- Эрчим хүчний хэмнэлттэй, сэргээгдэх эрчим хүчтэй холбоотой хувьцаа/сан
- Эрүүл мэнд, боловсролын салбарын нийгмийн хариуцлагатай хөрөнгө оруулалт

Байгалийн эрсдэл

Байгалийн гамшгийн хамгаалалт

Монгол орны уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй байгалийн эрсдэлүүд (ган, зуд, үер, хүчтэй салхи, хөрсний нуралт гэх мэт) нь даатгал, давхар даатгалын зах зээлд учруулах нөлөө нь өсөн нэмэгдэж байна. Манай компани эдгээр эрсдэлийн нөлөөллийг тооцох, дүн шинжилгээ хийх, эрсдэлийг шилжүүлэх шийдлүүдийг санхүүгийн хэрэгслээр дэмжих чиглэлд анхаарч ажиллаж байна.

Байгалийн гамшгийн нөхөн төлбөр


2024 онд нийт гамшгийн эрсдэлээс үүдэлтэй хөрөнгийн даатгал, малын индексжүүлсэн даатгал, хөдөө аж ахуйн даатгалын хохиролд компанийн зүгээс

**16.8 тэрбум
төгрөг**

нөхөн төлбөр олгосон
байна.

Даатгалын багцын бүтэц

Бид байгалийн гамшгийн даатгал, хөдөө аж ахуйн даатгал, үл хөдлөх хөрөнгийн даатгал зэрэг байгалийн хүчин зүйлд мэдрэмтгий бүтээгдэхүүнд давхар даатгалын дэмжлэг үзүүлж, даатгалын компаниудын эрсдэл даах чадварыг нэмэгдүүлдэг. Даатгалын багцын 18%-ийг Малын индексжүүлсэн даатгал эзэлдэг бөгөөд энэхүү даатгал нь малчдад байгаль цаг уурын эрс тэс нөхцөлөөс үүдэлтэй хохирлыг даван туулахад чухал ач холбогдолтой.



Байгалийн гамшгийн хамгаалалт

Малын индексжүүлсэн даатгал

Малын индексжүүлсэн даатгалыг 18 жилийн хугацаанд тасралтгүй хэрэгжүүлж давхардсан тоогоор 350 мянган малчин өрхийн 73.2 сая толгой малыг даатгалд хамруулж, 37 тэрбум 401 сая төгрөгийн хураамжийн орлого төвлөрүүлж 81.9 мянган малчин өрх нийт 29.0 тэрбум төгрөгийн нөхөн төлбөр авч, энэхүү даатгалын ач тусыг малчид бодитоор хүртээд байна. 2024 оны хувьд

21,425


Малчин өрх

106 тэрбум төгрөг

Нийт үнэлгээ

4.03 сая

Даатгасан малын тоо



2024 оны нийт хураамж: 4.965 тэрбум төгрөг

2024 оны нийт нөхөн төлбөр: 16.8 тэрбум төгрөг

Байгалийн гамшгийн хамгаалалт

Улаанбуудайн индексжүүлсэн даатгал

Монгол улсад гарах байгалийн гамшиг, гэнэтийн аюулын эрсдэлийн тоо хэмжээ нэмэгдэж байгаатай холбоотой манай компани 2018-2020 оны хооронд улаанбуудайн индексжүүлсэн даатгалаар дамжуулан тариалан эрхлэгчдэд 1.1 тэрбум төгрөгийн хохирлоос хамгаалсан. Улаан буудайн тариалан эрхлэгч нь 6-9 дүгээр сарын байгалийн бүхий л эрсдэлээс өөрийн улаан буудайн ургацаа хамгаалах юм.

Хамгаалах эрсдэлүүд



Ган

Хуурай халуун
салхи

Хүчтэй салхи



Цас, мөндөр



Гал түймэр

Үргэлжилсэн
бороо

Хүйтрэл, хяруу

Ургамлын
өвчин

Шавж, мэрэгч

Бусад нэмэлт
эрсдэл

Даатгалын үзүүлэлтүүд

413Даатгуулсан
ААН, иргэд**26,845**Даатгасан га
талбай**767.3** сая төгрөг

Нийт хураамж

1.1 тэрбум төгрөгОлгосон нийт нөхөн
төлбөр

03 Нийгэм

Тогтвортой ажлын байр

Тогтвортой хамтын ажиллагаа

Тогтвортой ханган нийлүүлэлтийн сүлжээ

Нийгэмд чиглэсэн үйл ажиллагаа

Тогтвортой ажлын байр

Манай байгууллага нь ажилтнууддаа урт хугацаанд өсөж хөгжих боломжийг олгосон, зохистой, тэгш орчныг бүрдүүлэхийг зорьж, хүний нөөцийн тогтвортой бодлогыг хэрэгжүүлэн ажиллаж байна. Бидний зүгээс дараах үндсэн чиглэлээр тогтвортой ажлын байрыг дэмжиж байна:



Ажилтны тогтвортой байдал



Ажиллах орчин, хөдөлмөрийн аюулгүй байдал



Цалин урамшууллын шударга тогтолцоо



Ур чадвар хөгжүүлэлт



Хүйсийн тэнцвэр, тэгш байдал

Нийт ажилтны 57% нь эмэгтэйчүүд бөгөөд удирдах түвшний 37.5%-ийг бүрдүүлж байна. Бид ажлын байрны тэгш байдал, ялгаварлан гадуурхахгүй байх зарчмыг баримталдаг.



46

Нийт ажилтны тоо



57%

Эмэгтэй ажилтнуудын
эзлэх хувь



1

Хөгжлийн бэрхшээлтэй
ажилтны тоо



37.5%

Гүйцэтгэх
удирдлагад эзлэх хувь



234 сая ₮

Нэмэлт цалин
урамшуулал



26.4 сая ₮

Ажилтнуудад олгосон
тусламж

Тогтвортой ажлын байр

Ажилтны тогтвортой байдлыг дэмжих

Байгууллагын ажилтны дундаж ажлын туршлага 5+ жил бөгөөд жил бүрийн ажилтны эргэлтийн түвшин зах зээлийн дунджаас доогуур байна. Ажилтны сэтгэл ханамжийн судалгааг жилд нэг удаа авч байгаа бөгөөд 2024 оны судалгааны үр дүн өмнөх онтой харьцуулахад ажилтнуудын сэтгэл ханамж нэмэгдсэн байна.

Гэр бүл, хүүхэд



Эрүүл мэнд



Ур чадвар

хөгжүүлэлт



- Ажилтан хурим хийх тохиолдолд ажлын 5 өдрийн чөлөө
- Эрэгтэй ажилтны эхнэр амаржсан тохиолдолд ажлын 10 өдрийн чөлөө
- Зайлшгүй шалтгаанаар хүнд өвчтэй эцэг, эх, нөхөр, хүүхэд гэх мэт хүмүүс асрах шаардлагатай тохиолдолд ажлын 40 хүртэл өдрийн цалинтай чөлөө олгодог.
- Гэр бүл болж байгаа, хүүхэд төрүүлсэн ажилтанд мөнгөн тусламж олгодог.

- Манай компани 2018 оноос хойш тасралтгүй нийт ажилтнуудаа эрүүл мэндийн даатгалд даатгуулж, урьдчилан сэргийлэх үзлэг, эмчилгээнд хамруулж байна.
- 2024 онд Улаанбаатар Мед нэгдсэн эмнэлэгтэй хамтран ажилтнуудаа эрт илрүүлгийн болон урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулсан.
- Компани байгуулагдсан цагаасаа хойш ажилтнуудынхаа эрүүл мэндэд анхаарч 7 хоногийн 1 өдөр спорт зааланд 2 цаг спортоор хичээллэдэг болсон.

- Ажилтнуудаа дэмжих хүрээнд мэргэжлийн сургалт, олон улсын чиг хандлагад нийцсэн хөтөлбөрүүдэд тогтмол хамруулдаг. 2024 онд давхардсан тоогоор 220 ажилтан нийт 40 цагийн дотоод болон гадаад сургалтад хамрагдсан.
- Нийт сургалтын зардал: 56 сая төгрөг
- Нийт сургалтын 77% нь мэргэшүүлэх сургалт байна.

Тогтвортой хамтын ажиллагаа

Үндэсний давхар даатгал ХК нь гадаад болон дотоод хамтын ажиллагааг эрхэмлэн “АА+” болон “А+” үнэлгээтэй дэлхийн шилдэг компаниуд Франц, Герман улсын давхар даатгагчидтай хамтран ажилладаг бөгөөд хамтын ажиллагаагаараа дамжуулан борлуулалтын сувгийг өргөжүүлэн давхар даатгалын үйлчилгээг экспортлон шинэ бүтээгдэхүүн үйлчилгээг нэвтрүүлэхээр олон улсын туршлага судлан хамтын ажиллагааг өргөжүүлэн ажиллаж байна. Мөн стратегийн түншийн харилцаа тогтоож олон улсын стандартад нийцсэн давхар даатгалын үйлчилгээг үзүүлж, эрсдэлийн тархаалтыг нэмэгдүүлэв.

Хамтран ажиллагч олон улсын давхар даатгагчид



+16

Олон улсын давхар
даатгагчид

+20

Даатгалын зуучлагчид
болон байгууллага

+50

Төрийн компани

Тогтвортой ханган нийлүүлэлтийн сүлжээ

Үндэсний Давхар Даатгал ХК нь байгууллагын үйл ажиллагаа болон нөлөөллийн хүрээгээрээ ханган нийлүүлэгчдийнхээ байгаль орчин, нийгэм, засаглалын (ESG) үзүүлэлтүүдэд анхаарах нь тогтвортой хөгжлийн үндэс гэж үзэн зөвхөн өөрийн дотоод үйл ажиллагааг тогтвортой байлгахаас гадна, эрсдэлгүй, ёс зүйтэй, нийгмийн хариуцлагатай, ил тод түншлэл бүхий ханган нийлүүлэлтийн сүлжээг бий болгоход чиглэж байна. Энэ хүрээнд бид дараах зарчмуудыг ханган нийлүүлэгч, түншлэлийн хэлэлцээрт тусгахыг зорьж байна.



Байгальд ээлтэй үйл ажиллагаа: Цаас багатай шийдэл, хог хаягдлын менежмент, байгалийн нөөцийн хэмнэлт



Хөдөлмөрийн эрх, хүний эрхийн хүндэтгэл: Хүүхдийн хөдөлмөр, албадан хөдөлмөрөөс ангид байдал



Ёс зүй, ил тод байдал: Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид, шударга бизнесийн зарчим



Хүний нөөцийн тэгш оролцоо: Жендерийн тэгш байдлыг дэмжсэн бодлого, оролцоо



36.7%

Нийт ханган нийлүүлэгчдийн тоонд байгаль орчин, нийгмийн шалгуураар сонгогдсон ханган нийлүүлэгчдийн хувь

Нийгэмд чиглэсэн үйл ажиллагаа

Зудын эрсдэлтэй аймгуудад байгалийн гамшгийн үр дагаврыг бууруулах зорилгоор том малын хорогдол ихтэй Баянхонгор, Сүхбаатар, Төв аймгуудад 50 тонн малын тэжээл, Баянхонгор аймагт 300 ширхэг амин тун багц, Архангай аймгийн Цэцэрлэг, Батцэнгэл, Хотонт, Төв аймгийн ЗДТГ, Баянхонгор аймгийн Галуут, Баацагаан, Заг, Баянбулаг, Увс аймгийн Баруунтуруун, Өвөрхангай аймгийн Баянгол сумдад зам гаргах, өвс тэжээл тээвэрлэхэд зориулж **нийт 212.6 сая төгрөгийн тусламж** олгосон.



Үндэсний давхар даатгал ХК үүсэн байгуулагдсаны 10 жилийн ойн хүрээнд “Миний мэддэг даатгал” гар зургийн уралдааныг улс орон даяар ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын дунд бага, дунд, ахлах гэсэн 3 насны ангиллаар зохион байгууллаа. Уралдаанд 50 гаруй бүтээл ирсэн бөгөөд тэдгээрийг компанийн 10 жилийн ойд зориулсан “Эрсдэлд тэсвэртэй-Монгол Улс” олон улсын форумын үеэр олон нийтэд танилцууллаа. 3 насны ангилалд эхний 3 байр эзэлсэн нийт 9 хүүхдэд өргөмжлөл, гарын бэлэг, мөнгөн шагнал олгов.



04 Засаглал

Компанийн засаглал

Ёс зүй ба комплаенс

Эрсдэлийн удирдлага

Мэдээллийн аюулгүй байдал

Компанийн засаглал

Манай компани тогтвортой хөгжилд суурилсан, ил тод, хариуцлагатай засаглалыг хэрэгжүүлэн ажиллаж байна. Засаглалын бүтэц нь компанийн эрх ашиг, хөрөнгө оруулагч, харилцагч, ажилтан болон бусад оролцогч талуудын итгэлийг бэхжүүлэх зорилготой. Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны 145 дугаар тогтоолоор батлагдсан “Компанийн засаглалын кодекс”-ыг үйл ажиллагаандаа хэрэгжүүлж ажилладаг. Кодексын 2024 оны хэрэгжилтийн өөрийн үнэлгээ 97.2%-тай байна.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРАЛ

Компанийн тухай хуульд заасны дагуу “Үндэсний давхар даатгал” ХК-ийн эрх барих дээд байгууллага нь хувьцаа эзэмшигчид (ХЭ)-ийн хурал байна. ХЭ-ийн хурлын бүрэн эрхийг Малын индексжүүлсэн даатгалын тухай хуульд заасны дагуу санхүүгийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн буюу Сангийн сайд хэрэгжүүлдэг.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ

Компанийн тухай хуулийн 75.1, Малын индексжүүлсэн даатгалын тухай хуулийн 21.2-т заасны дагуу ХЭ-ийн хурлын чөлөөт цагт компанийн эрх барих байгууллага нь Төлөөлөн удирдах зөвлөл (ТУЗ) юм. Компанийн тухай хууль, компанийн дүрэмд зааснаар ТУЗ 9 гишүүнтэй бөгөөд тэдгээрийн 3 нь хараат бус гишүүн байдаг. ТУЗ бүрэн эрхээ Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйл, Малын индексжүүлсэн даатгалын тухай хуулийн 21.2 болон бусад холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хэрэгжүүлэн ажилладаг.

ТУЗ нь үйл ажиллагаагаа байнгын, тогтмол, мэргэшсэн байдлаар зохион байгуулах зорилгоор дэргэдээ “Аудитын”, “Цалин, урамшууллын”, “Нэр дэвшүүлэх”, “Эрсдэлийн” гэсэн хороодыг байгуулсан.

ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГА

Компанийн тухай хуулийн 83 дугаар зүйл, Малын индексжүүлсэн даатгалын тухай хуулийн 22 дугаар зүйлд заасны дагуу компанийн гүйцэтгэх удирдлагыг Гүйцэтгэх захирал хэрэгжүүлдэг.

Гүйцэтгэх захирал нь ТУЗ-өөс олгосон эрх хэмжээний хүрээнд хэлцэл хийх, гэрээ байгуулах, компанийг төлөөлөх зэргээр компанийн нэрийн өмнөөс итгэмжлэлгүйгээр үйл ажиллагаа явуулдаг.

Ёс зүйн дүрэм

Компанийн эрх бүхий албан тушаалтан болон ажилтны үйл ажиллагаандаа баримтлах ёс зүйн хэм хэмжээг тогтоож, түүнийг мөрдүүлэх зорилгоор ТУЗ-ийн 2022 оны 29 дүгээр тогтоолоор "Ажилтны ёс зүйн дүрэм"-ийг шинэчлэн баталсан. Компанийн эрх бүхий албан тушаалтан болон ажилтны үйл ажиллагаандаа баримтлах ёс зүйн хэм хэмжээ, ёс зүйн шаардлагыг "Ажилтны ёс зүйн дүрэм"-ээр тогтоож, ТУЗ-ийн дэргэдэх "Нэр дэвшүүлэх хороо" болон Ёс зүйн хороо нь дүрэмд заасан чиг үүргийг хэрэгжүүлж ажилладаг.

ЁС ЗҮЙН ХЭМ ХЭМЖЭЭ

Хууль ёсыг эрхэмлэн
дээдлэх

Шударга ёсыг дээдэлж ашиг
сонирхлын зөрчлөөс ангид
байх

Даатгуулагчдад чин
сэтгэлээсээ үйлчилдэг байх

Хүний нэр төр, алдар хүнд,
эрхийг эрхэмлэн дээдлэх

Албан үүргээ биелүүлээгүй
улмаас хариуцлага хүлээдэг
байх

Захирах захирагдах ёсыг
сахих

Комплаенсын бодлого

Санхүүгийн зохицуулах хорооноос зохицуулалттай этгээдүүдэд зориулсан мэдээлэл, гарын авлагад тодорхойлсноор:

Комплаенс нь: компанийн засаглалын нэгэн хэсэг бөгөөд тухайн аж ахуйн нэгж, байгууллага хууль тогтоомж, журам, зааварт нийцүүлж үйл ажиллагаа явуулах чадамж юм.

Комплаенс гэдэг нь: италиар “complire”, испаниар “cumplir”, латинаар “complere” англиар “compliment” буюу гүйцэтгэх, гүйцээх, биелүүлэх гэсэн үгнүүдээс гаралтай.

Комплаенсын үйл ажиллагаа нь дараах 2 түвшинд явагддаг:

1. Тухайн байгууллагын мөрдөж ажиллах ёстой хууль тогтоомжууд, зохицуулагч байгууллагаас тавьсан шаардлага, мөрдөх ёстой хэм хэмжээг сахиулах;
2. Хууль эрх зүйн орчны хүрээнд тухайн байгууллагын дотооддоо баталсан дүрэм журмуудыг сахиулах.

Манай компани холбогдох хууль тогтоомж, салбарын зохицуулалт, дотоод дүрэм, журмын хэрэгжилтийг хангах, үйл ажиллагаандаа өндөр ёс зүй, ил тод байдлыг хэвшүүлэх зорилгоор СЗХ-оос баталсан "Компанийн засаглалын кодекс"-ыг үйл ажиллагаандаа мөрдөн ажилладаг. Тус кодекс нийцүүлэн компанийн засаглалын бодлого, шаардлагатай дүрэм, журмуудыг баталж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Тухайлбал: ТУЗ-ийн 2022 оны 27 дугаар тогтоолоор "Комплаенсын хяналтын журам"-ыг батлуулсан ба тус журмын дагуу ТУЗ-өөс томилогдсон комплаенсын ажилтан улирал бүр комплаенсын хяналтын тайлан гаргах, СЗХ, СМА-нд шаардлагатай тайлан мэдээг тухай бүр хүргүүлэх зэргээр компанийн комплаенсын бодлогыг хэрэгжүүлж ажилладаг.



Манай компанийн комплаенст хамаарах гол баримт бичгүүд:



Ажилтны ёс зүйн дүрэм



Комплаенсын хяналтын журам



Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх дотоод хяналтын болон эрсдэлийн удирдлагын хөтөлбөр

Эрсдэлийн удирдлага

Компанийн эрсдэлийн засаглал дараах зүйлсээс

бүрддэг. Үүнд:

- **Хамгаалалтын гурван шугам:** Нэгдүгээр шугам: Компанийн газар нэгжийн бүх ажилтан
Хоёрдугаар шугам: Компанийн Эрсдэлийн хороо болон Эрсдэл хариуцсан газар нэгж
Гуравдугаар шугам: Дотоод аудитын алба
- **Засаглалын баримт бичгүүд:** Бодлогын баримт бичиг, үйл ажиллагааны журам, аргачлал хамгаалалтын гурван шугамыг хэрэгжүүлэх баримт бичгүүд ордог.
- **Засаглалын хороо:** ТУЗ-ийн дэргэдэх Эрсдэлийн хороо, Компанийн Эрсдэлийн хороонууд
Эрсдэлийн удирдлагын тогтолцооны хэрэгжилтэд хяналт тавьж ажиллана.

Хамгаалалтын гурван шугам

Манай компани нь “Хамгаалалтын гурван шугам”-ын зарчим бүхий эрсдэлийн засаглалыг хэрэгжүүлснээр Компанийн дотоод хяналтын тогтолцоог сайжруулдаг.



Мэдээллийн аюулгүй байдал

Манай компани үйл ажиллагаандаа мэдээллийн нууцлал, бүрэн бүтэн байдал, хүртээмжийг хангах зорилгоор мэдээллийн аюулгүй байдлын бодлого, холбогдох хууль тогтоомжийг мөрддөг. Тухайлбал: Кибер аюулгүй байдлын тухай хууль, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль эдгээр хуультай нийцүүлэн эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас баталсан дүрэм, журам болон компанийн “Мэдээллийн аюулгүй байдлыг хангах журам”-ыг хэрэгжүүлж ажилладаг.

Мэдээллийн аюулгүй байдлыг хангах журмаар дараах асуудлыг зохицуулсан

Даатгуулагч, харилцагчийн
хувийн мэдээллийг
хамгаалах

Дотоод, гадаад кибер
эрсдэлээс урьдчилан
сэргийлэх

Үндсэн системийн
ажиллагааны тасралтгүй
байдлыг хангах

Санхүүгийн болон
эрсдэлийн өгөгдлийг
найдвартай хадгалах

05 Хавсралт

GRI стандарт

SASB удирдамж

НҮБ-ийн Тогтвортой хөгжлийн зорилгууд

БОНЗ, Тогтвортой байдлын тайлагналын удирдамж

Тайлагналын олон улсын стандарт /GRI/ индекс

GRI Код	Үзүүлэлтийн нэр	Холбоос/ тайлбар
GRI 2-1	Байгууллагын мэдээлэл	Удиртгал
GRI 2-2	Тогтвортой байдлын тайлагналд хамрагдсан этгээдүүд	Тогтвортой хөгжил: Материаллаг байдлын үнэлгээ
GRI 2-3	Тайлагналын хугацаа, давтамж	Удиртгал: Тайлангийн тухай
GRI 2-4	Мэдээллийн тодруулга	Удиртгал: Тайлангийн тухай
GRI 2-5	Хөндлөнгийн баталгаажуулалт	-
GRI 2-6	Үйл ажиллагаа үнэ цэнийн гинж	Нийгэм: Тогтвортой ханган нийлүүлэлтийн сүлжээ
GRI 2-7	Ажилтнууд	Нийгэм: Тогтвортой ажлын байр
GRI 2-8	Гэрээт ажилчид	-
GRI 2-9	Засаглалын бүтэц, бүрэлдэхүүн	Засаглал: Компанийн засаглал
GRI 2-10	ТУЗ-ийн гишүүдийн томилгоо, сонгон шалгаруулалт	Засаглал: Компанийн засаглал
GRI 2-11	ТУЗ-ийн үүрэг	Засаглал: Компанийн засаглал
GRI 2-12	Тогтвортой байдлын чиглэлээр байгууллагын удирдлагын үүрэг	Засаглал: Компанийн засаглал
GRI 2-13	Тогтвортой байдлыг удирдах хариуцлагын хуваарилалт	Засаглал: Компанийн засаглал
GRI 2-14	Тогтвортой байдлыг тайлагналд ТУЗ-ийн оролцоо	Засаглал: Компанийн засаглал
GRI 2-15	Ашиг сонирхлын зөрчил	Засаглал: Ёс зүйн дүрэм
GRI 2-16	Нэн чухал асуудлын харилцаа холбоо	Засаглал: Компанийн засаглал
GRI 2-17	ТУЗ-ийн ур чадвар	Төрийн өмчит компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнийг сонгон шалгаруулах нийтлэг журам, СЗХ-ны Тохиромжтой этгээдийг тодорхойлох журмын дагуу
GRI 2-18	Гүйцэтгэлийн үнэлгээ	Гүйцэтгэлийг үнэлэх, дүгнэх журам
GRI 2-19	Цалин урамшууллын бодлого	Цалин урамшууллын бодлогын баримт бичгээр зохицуулдаг.
GRI 2-20	Цалин урамшуулал тогтоох процесс	Хөдөлмөрийн дотоод журам
GRI 2-21	Цалингийн харьцаа	-
GRI 2-22	Тогтвортой хөгжлийн стратеги	Тогтвортой хөгжил
GRI 2-23	Бодлогын амлалт	Удиртгал
GRI 2-24	Бодлогын амлалт хэрэгжилт	-
GRI 2-25	Сөрөг нөлөөг сааруулах бодлого	Засаглал: Эрсдэлийн удирдлага
GRI 2-26	Зөвлөгөө авах, асуудал дэвшүүлэх механизм	Засаглал: Комплайнсын бодлого
GRI 2-27	Хууль зохицуулалтын орчны нийцэл	Засаглал: Комплайнсын бодлого
GRI 2-28	Гишүүнчлэл	Нийгэм: Тогтвортой ханган нийлүүлэлтийн сүлжээ
GRI 2-29	Оролцогч талуудын оролцоо	Нийгэм: Тогтвортой ханган нийлүүлэлтийн сүлжээ
GRI 2-30	Үйлдвэрчний эвлэл	Манай компани Үйлдвэрчний эвлэл байгуулан Монголын үйлдвэрчний эвлэлтэй хамтран ажилладаг.

Тайлагналын олон улсын стандарт /GRI/ индекс

GRI Код	Сэдэв	Үзүүлэлтийн нэр	Холбоос/ тайлбар
GRI 302-1	GRI 302: Эрчим хүч	Эрчим хүчний нийт хэрэглээ	Байгаль орчин: Тогтвортой хэрэглээ
GRI 302-4	GRI 302	Эрчим хүчний хэрэглээ бууруулах арга хэмжээ	Байгаль орчин: Тогтвортой хэрэглээ
GRI 305-1	GRI 305: Хүлэмжийн хий	Шууд ялгаруулалт (Scope 1)	Байгаль орчин: Тогтвортой хэрэглээ
GRI 305-2	GRI 305	Шууд бус ялгаруулалт (Scope 2)	Байгаль орчин: Тогтвортой хэрэглээ
GRI 305-3	GRI 305	Бусад шууд бус ялгаруулалт (Scope 3)	Байгаль орчин: Тогтвортой хэрэглээ
GRI 305-5	GRI 305	Ялгаруулалт бууруулах санаачилга ба үр нөлөө	Байгаль орчин: Тогтвортой хэрэглээ
GRI 401-1	GRI 401: Ажил эрхлэлт	Ажилтны элсэлт ба урсгал	Нийгэм: Тогтвортой ажилын байр
GRI 401-2	GRI 401	Ажилтны дэмжлэг	Нийгэм: Тогтвортой ажилын байр
GRI 401-3	GRI 401	Эцэг эхийн амралтын бодлого	Нийгэм: Тогтвортой ажилын байр
GRI 403-3	GRI 403 Хөдөлмөрийн аюулгүй байдал	Хөдөлмөрийн эрүүл мэндийн үйлчилгээ	Нийгэм: Тогтвортой ажилын байр
GRI 403-6	GRI 403	Эрүүл мэндийн үзлэгт хамрагдсан ажилчид	Нийгэм: Тогтвортой ажилын байр
GRI 404-1	GRI 404: Сургалт ба боловсрол	Сургалтын цаг	Нийгэм: Тогтвортой ажилын байр
GRI 405-1	GRI 405 Олон талт байдал, тэгш боломж	Ажилчдын олон талт байдал	Нийгэм: Тогтвортой ажилын байр
GRI 405-2	GRI 405	Өмэгтэйтэй ажилчдын цалингийн харьцаа эрэгтэйд харьцуулсан	Нийгэм: Тогтвортой ажилын байр
GRI 414-1	GRI 414 Нийлүүлэгчийн нийгмийн үнэлгээ	Шалгуур үзүүлэлтээр шалгагдсан нийлүүлэгчид	Нийгэм: Тогтвортой ханган нийлүүлэлтийн сүлжээ
GRI 414-2	GRI 414	Нийлүүлэлтийн сүлжээн дэх сөрөг нөлөөг бууруулах арга зам	Нийгэм: Тогтвортой ханган нийлүүлэлтийн сүлжээ

Тогтвортой байдлын нягтлан бодох бүртгэлийн стандартын зөвлөл /SASB/ - Даатгалын стандарт

Сэдэв	Код/Үзүүлэлтүүд	Тайлбар
Хэрэглэгчдэд зориулсан ил тод мэдээлэл, шударга зөвлөгөө	FN-IN-270a.1: Даатгалын бүтээгдэхүүнтэй холбоотой мэдээллийг шинэ болон хуучин хэрэглэгчдэд хүргэх, зах зээлд нэвтрүүлэхтэй холбоотой үйл ажиллагааны үр дүнд учирсан нийт хохирлын хэмжээ FN-IN-270a.2: Гомдол, нөхөн төлбөрийн харьцаа FN-IN-270a.3: Хэрэглэгчийг хадгалах түвшин	Харилцагчаас ирсэн гомдол байхгүй. Бусад холбогдох мэдээллийг гаргахаар ажиллаж байна.
	FN-IN-270a.4: Бүтээгдэхүүний талаар хэрэглэгчдэд мэдээлэх арга	Вэб сайт болон Midcalculator апп-аар дамжуулан мэдээлэл дамжуулж байна.
Хөрөнгө оруулалтын удирдлагад байгаль орчин, нийгэм, засаглалын хүчин зүйлсийг тусгах	FN-IN-410a.1: Салбар болон хөрөнгийн ангиллаар хөрөнгө оруулсан нийт хөрөнгө	Дэлгэрэнгүйг Байгаль орчин: Тогтвортой хөрөнгө оруулалт хэсгээс харна уу.
	FN-IN-410a.2: Хөрөнгө оруулалтын удирдлагын үйл явц, стратегид байгаль орчин, нийгэм, засаглалын (ESG) хүчин зүйлсийг тусгах	
Хариуцлагатай зан төлвийг төлөвшүүлэхэд чиглэсэн бодлого	FN-IN-410b.1: Эрчим хүчний хэмнэлт, нүүрстөрөгч багатай, технологийн шийдэлтэй холбоотой цэвэр хураамж	Энэ мэдээллийг гаргахаар ажиллаж байна.
	FN-IN-410b.2: Эрүүл мэнд, аюулгүй байдал, байгаль орчинд ээлтэй үйл ажиллагаа, зан төлөв ба бүтээгдэхүүний онцлог шинж чанаруудын талаарх бодлого	Дэлгэрэнгүйг Байгаль орчин: Байгалийн гамшигийн хамгаалалт хэсгээс харна уу.

Тогтвортой байдлын нягтлан бодох бүртгэлийн стандартын зөвлөл /SASB/ - Даатгалын стандарт

Сэдэв	Код/Үзүүлэлтүүд	Тайлбар
Байгаль орчны эрсдэлд өртөх	FN-IN-450a.1: Даатгалд хамрагдсан бүтээгдэхүүний байгаль цаг уураас шалтгаалж болзошгүй хамгийн их алдагдал (PML)	Энэхүү мэдээллийг гаргахаар ажиллаж байна.
	FN-IN-450a.2: (1) загварчлагдсан байгалийн гамшиг, (2) загварчлаагүй байгалийн гамшиг, үйл явдлын төрөл, газарзүйн сегментээр (давхар даатгалын цэвэр ба нийт) даатгалын төлбөртэй холбоотой мөнгөн хохирлын нийт дүн	Дэлгэрэнгүйг Байгаль орчин хэсгээс харна уу.
	FN-IN-450a.3: Байгаль орчны эрсдэлийг (1) андеррайтерийн үйл явц, (2) компанийн түвшний эрсдэл ба хөрөнгийн хүрэлцээний удирдлагад тусгах хандлага	Дэлгэрэнгүйг Байгаль орчин - Байгалийн эрсдэл хэсгээс харна уу.
Системчилсэн эрсдэлийн удирдлага	FN-IN-550a.1: Санхүүгийн үүсмэл хэрэгслийн эрсдэл ангилаллаар: (1) төвлөрсөн бус төлбөр тооцоогүй санхүүгийн үүсмэл хэрэгслийн нийт эрсдэл, (2) Төвлөрсөн төлбөр тооцооны төвд байршуулсан хүлээн зөвшөөрөгдөх барьцаа хөрөнгийн нийт бодит үнэ цэнэ, (3) төвлөрсөн төлбөр тооцоогүй үүсмэл хөрөнгийн нийт эрсдэл	Энэ төрлийн үйл ажиллагаа явуулдаггүй.
	FN-IN-550a.2: Зээлийн барьцаа хөрөнгийн нийт бодит үнэ цэнэ	Энэ төрлийн үйл ажиллагаа явуулдаггүй.
	FN-IN-550a.3: Даатгалын бус системийн үйл ажиллагаатай холбоотой хөрөнгийн болон хөрвөх чадвартай холбоотой эрсдэлийг удирдах арга барил	Засаглал: Эрсдэлийн удирдлага хэсгээс харна уу.

Тогтвортой байдлын нягтлан бодох бүртгэлийн стандартын зөвлөл /SASB/ - Хөрөнгийн удирдлага ба кастодионы үйл ажиллагааны стандарт

Сэдэв	Хэмжих	Тайлбар
Засаглал /Уур амьсгалын эрсдэл, боломжууд ба байгууллагын засаглалын уялдаа холбоо/	Уур амьсгалтай холбоотой эрсдэл, боломжуудын талаар Удирдах зөвлөлийн хяналт	Хяналтын тогтолцоог бүрдүүлэхээр ажиллаж байна.
	Уур амьсгалтай холбоотой эрсдэл, боломжуудыг үнэлэх, удирдах удирдлагын гүйцэтгэх үүрэг	Дэлгэрэнгүйг Засаглал: Компанийн засаглал хэсгээс харна уу.
Стратеги /Байгууллагын бизнес, стратеги, санхүүгийн төлөвлөлтөд уур амьсгалтай холбоотой эрсдэл, боломжуудын бодит болон боломжит нөлөөллийг ил тод болгох/	Байгууллагын богино, дунд, урт хугацаанд тодорхойлсон уур амьсгалтай холбоотой эрсдэл, боломжуудын нөлөөлөл	Дэлгэрэнгүйг Тогтвортой хөгжил: БОНЗ-ын тогтолцоо хэсгээс харна уу.
	Байгууллагын бизнес, стратеги, санхүүгийн төлөвлөлтөд уур амьсгалтай холбоотой эрсдэл, боломжуудын нөлөөлөл	Дэлгэрэнгүйг Тогтвортой хөгжил: Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал хэсгээс харна уу.
	Уур амьсгалтай холбоотой асуудлыг шийдэх арга, тухайлбал 2 градусаар бууруулах зэргийг харгалзан байгууллагын стратегийн тогтвортой байдлыг тайлбарлах	Энэхүү мэдээллийг гаргахаар ажиллаж байна.
Эрсдэлийн удирдлага /Байгууллага уур амьсгалтай холбоотой эрсдлийг хэрхэн тодорхойлж, үнэлж, удирддаг талаар тодруулах/	Уур амьсгалтай холбоотой эрсдэлийг тодорхойлох, үнэлэх байгууллагын үйл явц	Байгаль орчин: Байгалийн эрсдэл, хамгаалалт
	Уур амьсгалтай холбоотой эрсдэлийг удирдах байгууллагын үйл явц	
	Уур амьсгалтай холбоотой эрсдэлийг тодорхойлох, үнэлэх, удирдах үйл явц нь байгууллагын ерөнхий эрсдэлийн удирдлагад хэрхэн нэгтгэгдэж байгааг тайлбарлах	
Хэмжилт ба Зорилтот үзүүлэлтүүд /Уур амьсгалтай холбоотой эрсдэл, боломжуудыг үнэлэх, удирдахад ашигласан хэмжүүр, зорилтуудыг тодруулах/	Байгууллагын стратеги болон эрсдэлийн удирдлагын үйл явцтай уялдуулан уур амьсгалтай холбоотой эрсдэл, боломжийг үнэлэхэд ашигладаг хэмжүүрүүдийг тодруулах	Байгаль орчин: Тогтвортой хэрэглээ
	Хамрах хүрээ 1, Хамрах хүрээ 2, шаардлагатай бол 3-р хамрах хүрээний хүлэмжийн хийн ялгарал болон холбогдох эрсдэлийг тодруулах	
	Байгууллагын уур амьсгалтай холбоотой эрсдэл, боломжуудыг удирдахад ашигладаг зорилтууд болон зорилтот үзүүлэлтүүдийн гүйцэтгэлийг тайлбарлах	

	Хуудас	1 Лдүүргийг устгах	2 Өлсгөлөнг зогсоох	3 Эрүүл мэндийг дэмжих	4 Чанартай боловсролыг дэмжих	5 Жендерийн эрх зүйл байдлыг хангах	6 Байгаль орчныг хүрээлэн орчин дэмжих	7 Сэнгэжсэх энерги хэрэвч нэвтрүүлэх	8 Зохистой хөдөлмөр ба тайвн засвар өсөлтийг дэмжих	9 Инноваци болон дэд влчлалыг хөгжүүлэх	10 Тэгш бус байдлыг бууруулах	11 Эмгэг хот болон оронлог дэмжих	12 Хариуцлагатай хэрэгцээг дэмжих	13 Уур амьсгалын бүлэгжлийн хөдөлгөөн багасгах	14 Далай тэнгэрийн оронлогыг хамгаалах	15 Хуурай газрын эко системийг хамгаалах	16 Энх тайвны, шударга ёсыг цогцлоох	17 Хөгжлийн төлөх тусламж бэлдүүлэх
Удиртгал																		
Удирдлагын амлалт	02								●					●				●
Компанийн танилцуулга	03																	●
Тайлангийн тухай	05																	●
Тогтвортой хөгжил																		
Тогтвортой хөгжлийн стратеги	07																	
Материаллаг байдал	08								●					●				●
БОНЗ-ын тогтолцоо	09			●	●	●								●				●
Байгаль орчин																		
Тогтвортой хэрэглээ	10-12						●						●					
Тогтвортой хөрөнгө оруулалт	13								●			●		●				
Байгаль орчны эрсдэл	14	●												●				
Байгалийн гамшигийн хамгаалалт	15-16	●	●						●					●				
Нийгэм																		
Тогтвортой ажлын байр	18-19	●		●	●	●			●		●							
Тогтвортой хамтын ажиллагаа	20								●				●				●	●
Тогтвортой ханган нийлүүлэлтийн сүлжээ	21								●								●	●
Нийгэмд чиглэсэн үйл ажиллагаа	22	●			●				●					●				
Засаглал																		
Компанийн засаглал	24					●					●						●	●
Ёс зүй ба комплаенс	25-26						●				●						●	●
Эрсдэлийн удирдлага	27		●						●								●	●
Мэдээллийн аюулгүй байдал	28									●							●	
Хавсралт	29-38																	

Код	Ангилал	Шалгуур үзүүлэлтүүд	Тайлбар	Үзүүлэлт	Хэмжих нэгж	Тайлбар
MS Тогтвортой хөгжлийн удирдлагын тогтолцооны шалгуур үзүүлэлтүүд						
MS1.1	Тогтвортой хөгжлийн удирдлагын систем	Удирдлагын амлалт	Удирдлагаас баталсан тогтвортой хөгжлийн амлалт/мэдэгдэл байдаг эсэх	Үгүй		
MS2.1		Тогтвортой хөгжлийн бодлого, зохицуулалт	Тогтвортой хөгжлийн бодлого, зорилтуудыг тодорхойлж баталсан эсэх	Үгүй		
MS2.2			Тогтвортой хөгжлийн журам байдаг эсэх	Үгүй		
MS3.1			Танай компани тогтвортой хөгжлийн асуудал хариуцсан хороо байдаг эсэх	Үгүй		
MS3.2		Бүтэц удирдлага	ТУЗ-ийн түвшинд тогтвортой хөгжил / БОНЗ-ын асуудал хариуцсан гишүүн (бүтэн цагийн/ хавсран) байдаг эсэх	Үгүй		
MS3.3			Гүйцэтгэх удирдлагын түвшинд тогтвортой хөгжил/ БОНЗ-ын асуудал хариуцсан менежер (бүтэн цагийн/хавсран) байдаг эсэх	Үгүй		
MS3.4			Үйл ажиллагааны түвшинд тогтвортой хөгжил/ БОНЗ-ын асуудал хариуцсан албан тушаалтан (бүтэн цагийн/хавсран) байдаг эсэх	Тийм		Хавсран гүйцэтгэдэг.
MS3.5			Танай компани ТУЗ-ийн хурлын хөтөлбөрт тогтвортой хөгжлийн асуудлыг албан ёсоор тогтмол тусгадаг уу?	Үгүй		
MS4.1		Тогтвортой байдлын нөлөөллийн үнэлгээ	Танай компани эдийн засаг, байгаль орчин, нийгэмд үзүүлэх сөрөг нөлөөллөөс хэрхэн зайлсхийх, бууруулах, арилгах, эерэг үр нөлөөг сайжруулах талаар тайлбарласан нөлөөллийн процесс, үнэлгээ эсвэл матриц байдаг эсэх	Үгүй		
MS5.1		Чадавх бүрдүүлэлт	Нэг ажилтанд ногдох тогтвортой хөгжлийн тухай сургалтын жилийн дундаж цаг, хүйсээр	Үгүй		
MS6.1		Хяналт	Тогтвортой байдлын асуудал нь аудитын хорооны үйл ажиллагаа, дотоод хяналтын чиг үүрэгт хамаардаг уу?	Үгүй		
MS7.1		Тогтвортой байдлын тайлагнал	Танай компани тогтвортой байдал/ хөгжлийн тайлан (жилийн тайланд нэгтгэдэг эсвэл тусдаа тайлан)-гаа жил нэгээс доошгүй удаа тайлагнадаг уу?	Үгүй		
MS7.2			Танай компани уур амьсгалын эрсдэлийг олон улсын стандарт (УАӨСМТАХ, БОТСМТАХ)-ын дагуу тайлагнадаг уу?	Үгүй		
MS7.3			Тогтвортой хөгжлийн болон БОНЗ-ын мэдээллийг хөндлөнгийн байгууллагаар баталгаажуулдаг уу?	Үгүй		
MS8.1		Гишүүнчлэл, хамтын ажиллагаа	Танай компани тогтвортой хөгжлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг олон улсын болон дотоодын холбоо, нэгдэлтэй нэгдэж хамтран ажилладаг уу? Үүнд, хүний эрх болон бизнесийн тунхаглал орно.	Үгүй		

Код	Ангилал	Шалгуур үзүүлэлтүүд	Тайлбар	Үзүүлэлт	Тайлбар
S	Нийгмийн шалгуур үзүүлэлтүүд				
S1.1	Хүний нөөц	Хүний нөөцийн тогтвортой байдал	Үндсэн ажилтнуудын ажлын байрны сэлгээний хувь (тухайн онд ажлаасаа гарсан ажилтнуудын тоог ажилласан ажилтнуудын дундаж тоонд хуваах)	0.15%	
S1.2		Шинээр бий болгосон ажлын байр	Өмнөх оны мөн үеэс нэмэгдсэн бүтэн цагийн ажлын байрны тоо	0	
S1.3		Сургалт	Нэг ажилтанд ногдох жилийн дундаж сургалтын цаг	8 цаг	
S2.1	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй (ХАБЭА)	ХАБЭА-н бодлого	ХАБЭА-н бодлого, журам бий юу (тусдаа бодлого журам эсвэл аль нэг журамд нэгтгэсэн)?	байхгүй	
S2.2		Осол аваар	Үйл ажиллагааны явцад гарсан осол аваарын хувь	0%	
S2.3		ХАБЭА-н сургалт	Жилд нэг ажилтанд ногдох дундаж ХАБЭА сургалтын цаг	0 цаг	
S2.4		Эрүүл мэндийн хөтөлбөр	Эрүүл мэндийн үзлэг зэрэг сайн дурын эрүүл мэндийн үйлчилгээнд хамрагдсан ажилчдын тоо, жилээр	41 хүн	
S3.1	Эрх тэгш байдал	Жендерийн бодлого, журам	Жендерийн бодлого, журам бий юу (тусдаа бодлого журам эсвэл аль нэг журамд нэгтгэсэн)?	Үгүй	
S3.2		Ажлын байрны бэлгийн дарамтын эсрэг бодлого, журам	Бэлгийн дарамтын эсрэг бодлого, журам бий юу (тусдаа бодлого журам эсвэл аль нэг журамд нэгтгэсэн)?	Тийм / Ёс зүйн дүрэмд холбогдох заалтууд орсон/	
S3.3		Ялгаварлан гадуурхалтын эсрэг бодлого, журам	Ялгаварлан гадуурхалтын эсрэг бодлого, журам бий юу (тусдаа бодлого журам эсвэл аль нэг журамд нэгтгэсэн)?	Тийм / Ёс зүйн дүрэмд холбогдох заалтууд орсон/	
S3.4		Ажилтнуудын хүйсийн харьцаа	Нийт үндсэн ажилтнуудын тоонд эрэгтэй, эмэгтэй ажилтны эзлэх хувь	Эр-43%, Эм-57%	
S3.5		Удирдах зөвлөлийн хүйсийн харьцаа	Удирдах зөвлөлийн гишүүдийн эрэгтэй, эмэгтэй хүйсийн харьцаа	Эр - 88.9%, Эм - 11.1%	
S3.6		Гүйцэтгэх удирдлагын хүйсийн харьцаа	Гүйцэтгэх удирдлагын түвшний ажилтнуудын эрэгтэй, эмэгтэй хүйсийн харьцаа	Эр - 63%, Эм-37%	
S3.7		Дунд болон анхан шатны нэгжийн ажилтнуудын хүйсийн харьцаа	Дунд болон анхан шатны нэгжийн ажилтнуудын эрэгтэй, эмэгтэй хүйсийн харьцаа	Эр - 31%, Эм-69%	
S3.8		Жендерт суурилсан цалингийн зөрүү	Эрэгтэй ба эмэгтэй ажилтнуудын дундаж цалингийн харьцаа	Харьцаа 50.4:49.6	

Код	Ангилал	Шалгуур үзүүлэлтүүд	Тайлбар	Үзүүлэлт	Тайлбар
S	Нийгмийн шалгуур үзүүлэлтүүд				
S1.1	Хүний нөөц	Хүний нөөцийн тогтвортой байдал	Үндсэн ажилтнуудын ажлын байрны сэлгээний хувь (тухайн онд ажлаасаа гарсан ажилтнуудын тоог ажилласан ажилтнуудын дундаж тоонд хуваах)	0.15%	
S1.2		Шинээр бий болгосон ажлын байр	Өмнөх оны мөн үеэс нэмэгдсэн бүтэн цагийн ажлын байрны тоо	0	
S1.3		Сургалт	Нэг ажилтанд ногдох жилийн дундаж сургалтын цаг	8 цаг	
S2.1	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй (ХАБЭА)	ХАБЭА-н бодлого	ХАБЭА-н бодлого, журам бий юу (тусдаа бодлого журам эсвэл аль нэг журамд нэгтгэсэн)?	байхгүй	
S2.2		Осол аваар	Үйл ажиллагааны явцад гарсан осол аваарын хувь	0%	
S2.3		ХАБЭА-н сургалт	Жилд нэг ажилтанд ногдох дундаж ХАБЭА сургалтын цаг	0 цаг	
S2.4		Эрүүл мэндийн хөтөлбөр	Эрүүл мэндийн үзлэг зэрэг сайн дурын эрүүл мэндийн үйлчилгээнд хамрагдсан ажилчдын тоо, жилээр	41 хүн	
S3.1	Эрх тэгш байдал	Жендерийн бодлого, журам	Жендерийн бодлого, журам бий юу (тусдаа бодлого журам эсвэл аль нэг журамд нэгтгэсэн)?	Үгүй	
S3.2		Ажлын байрны бэлгийн дарамтын эсрэг бодлого, журам	Бэлгийн дарамтын эсрэг бодлого, журам бий юу (тусдаа бодлого журам эсвэл аль нэг журамд нэгтгэсэн)?	Тийм / Ёс зүйн дүрэмд холбогдох заалтууд орсон/	
S3.3		Ялгаварлан гадуурхалтын эсрэг бодлого, журам	Ялгаварлан гадуурхалтын эсрэг бодлого, журам бий юу (тусдаа бодлого журам эсвэл аль нэг журамд нэгтгэсэн)?	Тийм / Ёс зүйн дүрэмд холбогдох заалтууд орсон/	
S3.4		Ажилтнуудын хүйсийн харьцаа	Нийт үндсэн ажилтнуудын тоонд эрэгтэй, эмэгтэй ажилтны эзлэх хувь	Эр-43%, Эм-57%	
S3.5		Удирдах зөвлөлийн хүйсийн харьцаа	Удирдах зөвлөлийн гишүүдийн эрэгтэй, эмэгтэй хүйсийн харьцаа	Эр - 88.9%, Эм -11.1%	
S3.6		Гүйцэтгэх удирдлагын хүйсийн харьцаа	Гүйцэтгэх удирдлагын түвшний ажилтнуудын эрэгтэй, эмэгтэй хүйсийн харьцаа	Эр -63%, Эм-37%	
S3.7		Дунд болон анхан шатны нэгжийн ажилтнуудын хүйсийн харьцаа	Дунд болон анхан шатны нэгжийн ажилтнуудын эрэгтэй, эмэгтэй хүйсийн харьцаа	Эр -31%, Эм-69%	
S3.8		Жендерт суурилсан цалингийн зөрүү	Эрэгтэй ба эмэгтэй ажилтнуудын дундаж цалингийн харьцаа	Харьцаа 50.4:49.6	

Код	Ангилал		Шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Тайлбар
E	Байгаль орчны шалгуур үзүүлэлтүүд				
E1.1	Эрчим хүч	Нийт эрчим хүчний хэрэглээ	Эрчим хүчний нийт зарцуулалтын хэмжээ болон зардал	кВт.ц	
E1.2		Цахилгаан	Цахилгааны нийт зарцуулалтын хэмжээ болон хэмнэлт (жилээр)	98000 кВт.ц	Тооцох боломжгүй.
E1.3		Дулаан	Дулааны нийт зарцуулалтын хэмжээ болон хэмнэлт (жилээр)	365 гкал	
E1.4		Түлш	Түлшний нийт зарцуулалтын хэмжээ болон хэмнэлт (жилээр). Үүнд, Халаах зорилгоор хэрэглэсэн түлбуюу нүүрс, хий Тээврийн зардалд ашигласан түлш буюу бензин, дизель	2422 литр	
E1.5		Хүрэн эрчим хүч	СЭХ-ээс бусад эх үүсвэрээс авсан эрчим хүчний хэрэглээний хувь	0%	
E1.6		Сэргээгдэх эрчим хүч	СЭХ үүсвэрээс гаргаж авсан эрчим хүчний хэрэглээний хувь	0%	
E2.1	Хүлэмжийн хийн ялгарал	3.1 Хүлэмжийн хийн ялгаруулалт	Компанийн шууд ба шууд бус үйл ажиллагаанаас ялгарсан нийт хүлэмжийн хийн дүн	CO2/тонн	Байгаль орчин: Тогтвортой хэрэглээс хэсгээс харна уу.
E2.2		3.2 Бууруулсан хүлэмжийн хий	Байгууллагын шууд ба шууд бус үйл ажиллагаанаас ялгарсан хүлэмжийн хийн нийт дүн (жилээр)	CO2/тонн	Байгаль орчин: Тогтвортой хэрэглээс хэсгээс харна уу.
E2.3		3.3 Дүйцүүлэх арга хэмжээ /Карбон офсет/	Нийт карбон офсет буюу дүйцүүлэх арга хэмжээний (мод тарих хөтөлбөр, эсвэл хүлэмжийн хийг бууруулах гадны төслийг дэмжих гэх мэт)бууралт	CO2/тонн	2024 онд 50 бут буйлс мод тарьсан.
E3.1	Уур амьсгалын өөрчлөлт	Уур амьсгалын бодлого, журам	Танай компани уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг тусдаа эсвэл бусад журамд тусгасан бодлоготой юу?	Үгүй	
E3.2		Уур амьсгалын эрсдэл ба боломжийн үнэлгээ	Танай компани уур амьсгалын эрсдэл, боломжийн талаарх үнэлгээ хийсэн үү? (сценарийн шинжилгээ, стресс тест гэх мэт)	Үгүй	
E3.3		Эдийн засгийн хохирол	Уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй гамшиг, үйл явдлын улмаас учирсан эдийн засгийн нийт хохирлын хэмжээ	18 тэрбум төгрөг	Малын индексжүүлсэн даатгалын малчдад олгосон нөхөн төлбөр
E3.4		Уур амьсгалын хөрөнгө оруулалт	Уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг дэд бүтэц, дасан зохицол, бүтээгдэхүүн хөгжилд оруулсан нийт хөрөнгө оруулалтын дүн	15.0 орчим тэрбум төгрөг	
E3.5		Уур амьсгалын өөрчлөлт	Уур амьсгалын өөрчлөлттэй холбоотойгоор танай компанийн ашигт ажиллагаа эсвэл бүтээгдэхүүн, үйлчилгээний чанарт нөлөөлөх эрсдэлээс урьдчилан сэргийлэх, (хэрэв урьдчилан сэргийлэх боломжгүй бол) дасан зохицох чиглэлд хэрэгжүүлэх арга хэмжээ/ алхмуудыг тодорхойлсон уу?	Тийм	Гамшгийн эсрэг даатгалын бүтээгдэхүүнийг боловсруулж Сангийн яаманд хүргүүлсэн

Код	Ангилал	Шалгуур үзүүлэлтүүд	Тайлбар	Үзүүлэлт	Тайлбар
S	Нийгмийн шалгуур үзүүлэлтүүд				
S4.1	Хүртээмжтэй байдал	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн бодлого, журам	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан олон нийтэд нээлттэй бодлого, журам бий юу (тусдаа бодлого журам эсвэл аль нэг журамд нэгтгэсэн)?	Үгүй	
S4.2		Хөгжлийн бэрхшээлтэй ажилтнууд	Хөгжлийн бэрхшээлтэй ажилтнуудын нийт ажилтны тоонд эзлэх хувь	2.4%	
S4.3		Оффисын хүртээмж	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хүртээмжтэй байдлаар шийдсэн оффис, байгууламжтай юу?	Үгүй	
S4.4		Торгууль	Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хамгаалах тухай хууль тогтоомжийг дагаж мөрдөөгүйн улмаас төлсөн торгуулийн хэмжээ	Байхгүй	
S5.1	Нийгмийн хариуцлага ба олон нийтийн оролцоо	Оролцогч талуудын оролцооны засаглал	Оролцогч талуудтай хамтарч ажиллах талаар тусгайлсан бодлого байгаа юу?	Тийм	
S5.2		Нийгмийн нөлөөллийн үнэлгээ, газар чөлөөлөлтийн бодлого журам	Танай компани нийгэмд нөлөөлөх байдлын бодлого, журамтай юу?	Үгүй	
S5.3		Санал гомдлыг шийдвэрлэх бодлого/ журам	Гомдол маргааныг шийдвэрлэх бодлого, механизм бий юу?	Тийм	
S5.4		Олон нийтэд ил тод мэдээлэх	Танай компанийн үйл ажиллагаа нөлөөлж буй иргэдэд мэдээлэл өгөх, санал хүсэлт авч, гомдол шийдвэрлэх тогтолцоо бий юу?	Тийм	
S5.5		Ажилчид/олон нийтийн санал гомдол	Ажилчид болон олон нийтээс ирсэн санал гомдлыг шийдвэрлэсэн хувь	100% шийдсэн	
S5.6		Нийгмийн хариуцлагын үйл ажиллагаанд зарцуулсан хөрөнгө оруулалт	Нийгмийн хариуцлагын арга хэмжээ, хөтөлбөрт зарцуулсан хөрөнгө оруулалтын нийт орлогод эзлэх хувь, ТХЗ-оор ангилсан	0.87%	
S6.1	Тогтвортой өртгийн сүлжээний менежмент	Худалдан авалтын бодлого, журам	Танай компанид дотоодын худалдан авалт болон тогтвортой буюу байгаль орчин, нийгмийн эрсдэл боломжийг хангасан худалдан авалтын бодлого, журам бий юу?	Үгүй	Худалдан авалтын үйл ажиллагаа ТБОНӨХБАҮХАТухай хуулийн дагуу явагддаг
S6.2		Дотоодын худалдан авалт	Дотоодын ханган нийлүүлэгчдээс авсан худалдан авалтын хувь	100%	Бараа 59.10% Үйлчилгээ 40.90%
S6.3		Тогтвортой, ногоон худалдан авалт	Нийт ханган нийлүүлэгчдийн тоонд тогтвортой буюу байгаль орчин, нийгмийн шалгуураар сонгогдсон ханган нийлүүлэгчдийн хувь	36.72%	Нийгэм: Тогтвортой ханган нийлүүлэлт
G1.1	Компанийн засаглал	Компанийн засаглалын бодлого журам	Шинээр батлагдсан Кодексийн дагуу компанийн засаглалын бодлого, журам бий юу, уг журмын тайлагнал хийдэг үү?	Тийм	Засаглал: Ёс зүйн дүрэм
G1.2		Удирдах зөвлөлийн хараат бус байдал	Удирдах зөвлөлд хараат бус гишүүдийн суудлын хувь	33.3%	
G1.3		Цөөнх, жижиг хувьцаа эзэмшигчдийн эрх	Цөөнх, жижиг хувьцаа эзэмшигчдийн эрхийг хамгаалах дүрэм, журам бий юу?	Тийм	
G2.1	Авлигал болон ёс зүй	Авлига, хээл хахуулийн эсрэг бодлого журам	Авлигын эсрэг эсвэл Ёс зүйн бодлого, журам бий юу?	Тийм	Засаглал: Ёс зүйн дүрэм
G3.1	Комплаенс	Комплаенсын бодлого	Комплаенсын бодлого, журам бий юу?	Тийм	Засаглал: Комплаинсын бодлого
G3.2		Комплаенсын хөтөлбөр	Комплаенсын хөтөлбөр, журам	Тийм	Засаглал: Комплаинсын бодлого